


Ипотекийн зээлийн тайлан

2015 оны 7 дугаар сар

Банкууд 2015 оны 7 дугаар сард нийт 1161 зээлдэгчид 61.6 тэрбум төгрөгийн ипотекийн зээл шинээр олгосноор банкуудын ипотекийн зээлийн үлдэгдэл 3230.5¹ тэрбум төгрөг, нийт зээлдэгчдийн тоо 73208-т хүрчээ.

Тайлант сарын эцэст банкуудын ипотекийн зээлийн үлдэгдлийн жилийн өсөлтийн хурд өмнөх сартай харьцуулахад 1.2 нэгж хувиар, оны эхнээс 17.1 нэгж хувиар, өмнөх оны мөн үеэс 66.1 нэгж хувиар буурсан байна.



Тайлант сарын эцэст банкуудын ипотекийн зээлийн үлдэгдлийн 74.3 хувь буюу 2400.6 тэрбум төгрөгийг “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр”-ийн зээл (жилийн 8 хувийн хүүтэй зээл болон 8 хувийн хүүтэй зээлд шилжүүлсэн зээл), 23.6 хувь буюу 762.9

тэрбум төгрөгийг банкуудын өөрийн эх үүсвэрээр олгосон зээл, 2.1 хувь буюу 67.0 тэрбум төгрөгийг бусад эх үүсвэрээр олгосон зээл бүрдүүлж байна.



2015 оны 7 дугаар сарын байдлаар ипотекийн зээлийн үлдэгдлийн 98.3 хувь нь төгрөгийн зээл, 1.7 хувь нь гадаад валютын зээл байна.

Ипотекийн зээлийн үлдэгдэлд эзлэх хугацаа хэтэрсэн зээлийн хувь 2015 оны 7 дугаар сарын байдлаар 2.3 хувь, чанаргүй зээлийн эзлэх хувь 0.6 байна.



¹ МИК-т шилжүүлсэн 1506.7 тэрбум төгрөгийн зээлийн дүн орсноор.

Тайлант сард олгосон зээл

Тухайн сард олгосон ипотекийн зээл өмнөх сараас 38.5 хувиар, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 20.3 хувиар буурсан байна.



Тайлант сард шинээр олгосон зээлийн 74.1 хувь буюу 45.6 тэрбум төгрөг нь “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр”-ийн зээл, 25.9 хувь буюу 16.0 тэрбум төгрөг нь банкуудын өөрийн эх үүсвэрээс олгосон зээл байна.



Нэг зээлдэгчид ногдох олгосон зээлийн хэмжээ 2015 оны 7 дугаар сарын байдлаар 53.1 сая төгрөг байна.

Тухайн сард 24.3 тэрбум төгрөгийн ипотекийн зээл төлөгдсөн нь өмнөх сараас 36.0 хувиар, өмнөх оны мөн үеэс 8.7 хувиар буурсан байна.



Зээлдэгчдийн тоо

Тайлант сард нийт 1161 зээлдэгч шинээр ипотекийн зээлд хамрагдсанаас 766 зээлдэгч “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр”-ийн зээлд, 395 зээлдэгч банкны өөрийн эх үүсвэрийн зээлд хамрагдсан байна.



2015 оны 7 дугаар сарын байдлаар нийт 73208 иргэн ипотекийн зээлтэй байгаагаас 52181 нь “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр”-ийн зээлд, 19047 нь банкуудын өөрийн эх үүсвэрийн зээлд, 1980 нь бусад эх үүсвэрийн зээлд хамрагдсан байна.



Зээлийн хугацаа

Тайлант сард банкууд 0.5-20 жилийн хугацаатай зээл олгосон бөгөөд жигнэсэн дундаж хугацаа нь 16.1 жил байна. Ипотекийн зээлийн үлдэгдлийн жигнэсэн дундаж хугацаа 2015 оны 7 дугаар сарын байдлаар 15.5 жил байна.

Тухайн сард олгосон зээлийн дийлэнх буюу 59.6 хувь нь 16-20 жилийн хугацаатайгаар олгогдсон. Нийт ипотекийн зээлийн үлдэгдлийн 65.6 хувь нь 16-20 жил, 20.5 хувь нь 11-15 жил, 11.6 хувь нь 6-10 жил, 2.2 хувь нь 1-5 жилийн хугацаатай байна.



Зээлийн хүү

Банкуудын 2015 оны 7 дугаар сард олгосон ипотекийн зээлийн жигнэсэн дундаж хүү 9.9 хувь байв. “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр” хэрэгжиж эхлэхээс өмнөх үетэй харьцуулахад жигнэсэн дундаж хүү 6.7 нэгж хувиар буурсан байна.



Банкуудын өөрийн эх үүсвэрээр олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү 15.5 хувь байв.

Хавсралт 1. Банкуудын ипотекийн зээлийн тайлан

Он	Сар	Ипотекийн зээлийн үлдэгдэл (сая төг.)	Үүнээс:	Тайлант сард шинээр олгосон зээлийн жигнэсэн дундаж хугацаа (сараар)	Тухайн сард олгосон зээлийн ЖДХүү, жилээр (%)	Нийт зээлдэгч (тоогоор)	Үүнээс:
			ОСИСТГБ хөтөлбөрийн зээл				ОСИСТГБ хөтөлбөрийн зээлтэй
2008	12	217,977.5		100.7	19.8	16,522	
2009	12	226,040.6		103.4	18.7	16,784	
2010	12	333,776.6		115.0	16.0	19,700	
2011	12	669,662.8		154.3	14.8	26,869	
2012	12	845,204.4		155.5	15.3	29,887	
2013	12	1,938,945.3	1,248,633.8	192.8	9.9	48,320	30,600
2014	1	2,021,424.9	1,324,898.9	194.4	9.8	49,731	32,190
	2	2,121,802.6	1,382,084.1	193.2	9.9	53,611	33,346
	3	2,193,368.6	1,451,938.1	190.7	9.9	54,787	34,632
	4	2,280,503.5	1,538,506.8	192.1	9.8	56,137	36,081
	5	2,365,349.5	1,618,127.2	189.3	10	57,579	37,488
	6	2,440,007.1	1,684,583.9	182.3	10.5	58,793	38,659
	7	2,492,105.2	1,728,222.8	187.9	10.7	59,756	39,507
	8	2,553,827.2	1,780,078.3	186.7	10.5	60,851	40,405
	9	2,619,161.1	1,833,494.0	185.9	10.6	62,017	41,390
	10	2,703,792.6	1,903,636.6	189.3	10.4	63,652	42,772
	11	2,762,633.1	1,954,247.6	194.5	10.3	64,577	43,621
	12	2,844,612.6	2,027,859.2	200.1	9.9	66,334	45,283
2015	1	2,898,836.5	2,073,000.1	195.9	10.2	67,233	46,134
	2	2,949,222.0	2,121,445.2	198.6	9.7	68,126	47,108
	3	3,015,640.6	2,196,901.0	197.7	9.2	69,269	48,512
	4	3,082,657.3	2,263,900.1	199.2	9.6	70,498	49,691
	5	3,127,876.7	2,305,002.4	197.3	10.3	71,355	50,462
	6	3,192,029.5	2,363,674.5	197.2	9.6	72,412	51,438
	7	3,230,507.8	2,400,625.2	193.2	9.9	73,208	52,181

Хавсралт 2. Орон нутгийн банкуудын ипотекийн зээлийн тайлан

2015 оны 7 дугаар сарын байдлаар

Аймгууд	Ипотекийн зээлийн		Үүнээс ОСИСТБХ-ийн зээл		Тухайн сард олгосон ипотекийн зээлийн ЖДХугацаа (сар)	Тухайн сард олгосон ипотекийн зээлийн ЖДХүү (жилээр)	Нийт зээлдэгчдийн тоо	Үүнээс: ОСИСТБХ хөтөлбөрийн зээлтэй
	Үлдэгдэл (сая төг.)	Эзлэх хувь	Үлдэгдэл (сая төг.)	Эзлэх хувь				
1 Улаанбаатар	2,476,074.5	76.6%	1,801,285.1	75.0%	199.1	9.8	49263	47,145
2 Дархан-Уул	113,379.2	3.5%	99,248.5	4.1%	205.9	9.9	3346	574
3 Орхон	107,492.8	3.3%	92,968.6	3.9%	178.1	9.6	2854	535
4 Дорноговь	66,597.8	2.1%	54,230.3	2.3%	200.0	8.6	1954	534
5 Дорнод	45,796.1	1.4%	40,687.0	1.7%	171.3	10.7	1467	404
6 Сэлэнгэ	44,609.1	1.4%	35,137.6	1.5%	198.3	7.8	1539	195
7 Өвөрхангай	41,705.7	1.3%	29,211.7	1.2%	175.5	11.8	1468	301
8 Увс	40,706.8	1.3%	29,397.2	1.2%	148.3	14.7	1371	265
9 Өмнөговь	39,512.6	1.2%	29,724.2	1.2%	167.3	11.8	1104	266
10 Баянхонгор	36,945.4	1.1%	33,624.0	1.4%	188.8	9.5	1061	428
11 Ховд	30,507.8	0.9%	25,188.1	1.0%	167.5	10.8	1036	280
12 Сүхбаатар	25,107.5	0.8%	17,048.5	0.7%	175.4	10.6	860	212
13 Архангай	21,818.8	0.7%	16,895.1	0.7%	168.7	9.0	649	141
14 Баян-Өлгий	21,408.6	0.7%	10,946.2	0.5%	109.0	17.7	1050	116
15 Говь-Алтай	18,631.6	0.6%	15,052.8	0.6%	182.7	9.6	605	141
16 Хөвсгөл	17,166.3	0.5%	9,172.3	0.4%	153.2	11.1	702	97
17 Завхан	16,524.3	0.5%	10,119.1	0.4%	140.2	14.8	731	95
18 Хэнтий	15,181.0	0.5%	12,881.5	0.5%	210.8	8.8	456	129
19 Дундговь	13,743.6	0.4%	10,745.8	0.4%	150.9	13.0	429	86
20 Төв	13,640.4	0.4%	9,953.4	0.4%	155.3	8.8	438	81
21 Говьсүмбэр	12,278.2	0.4%	10,986.1	0.5%	163.3	10.9	398	111
22 Булган	11,679.6	0.4%	6,121.9	0.3%	170.0	11.9	427	45
Нийт	3,230,507.8	100%	2,400,625.2	100%	193.2	9.9	73208	52181

2015 оны 7 дугаар сарын байдлаар банкуудын ипотекийн зээлийн үлдэгдлийн 76.6 хувийг Улаанбаатар хотод, 23.4 хувийг хөдөө орон нутагт олгосон ипотекийн зээл бүрдүүлжээ. Хөдөө орон нутаг дахь ипотекийн зээлийн үлдэгдлийн 15.0 хувь буюу 113.4 тэрбум төгрөг Дархан-Уул аймагт, 14.2 хувь буюу 107.5 тэрбум төгрөг Орхон аймагт, 8.8 хувь буюу 66.6 тэрбум төгрөг Дорноговь аймагт ногдож байна.